



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/310

Арвайхээр

**“Тогтвортой амьжиргаа-3” төслийн үйл
ажиллагааг дэмжих баг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.“б” заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн банк, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Сангийн яамнаас хэрэгжүүлж буй “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэгтэй аймгийн чадавх бэхжүүлэх баг (АЧББ)-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: -Аймгийн иргэдийн Төлөөлөгчлийн Хурлын нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан мэргэжилтэн

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

2. Төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг аймгийн чадавх бэхжүүлэх багт үүрэг болгосугай.

3. Дээрх захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 20 ны өдрийн “Тогтвортой амьжиргаа-3” төслийн үйл ажиллагааг дэмжих баг байгуулах тухай” А/177 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100548